17	Тарга ухаа	Т.Батжаргал		Зун, намрын улиралд ашиглана	
18	Чулуут			Хавар, намар, зуны улиралд ашиглана	

[3] Сүхбаатар аймгийн Дарьганга сумын 2011 оны худгийн бүртгэл

№	Худгийн нэр	Эзэмшигчийн нэр	Гаргасан огноо	Ашиглалт	Тайлбар
19	Агт булаг	Б.Сэргэлэн		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
20	Өрнө дэрс			Хавар, намар, зуны улиралд ашиглана	
21	Хавцал			Өвлийн улиралд ашиглана	
22	Үүд	Д.Хатанбаатар		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
23	Таван толгой	М.Батжаргал		Өвлийн улиралд ашиглана	
24	Цамхаг	Г.Бор Б.Ганболд,		Өвлийн улиралд ашиглана	
25	Хавцал	Б.Алдарбаяр, Ж.Моононшар		Өвлийн улиралд ашиглана	
26	Ногоон хоолой	Ч.Мөнхбаатар, Н.Азжаргал		Зун, намрын улиралд ашиглана	
27	Бадрах	Ө.Мэндсайхан, Д.Өлзийбаяр, Б.Батаа		Өвлийн улиралд ашиглана	
28	Бадрах	Ц.Батхүрэл Б.Батаа Б.Сонинбаяр		Өвлийн улиралд ашиглана	
29	Баарай худаг	Б.Бямбадорж		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
30	өрнөдэрс	Л.Батцэнгэл		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
31	Өрнөдэрс	Л.Энхбаатар		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
32	Хойморын худаг	С.Эрдэнэсүх М.Уламбаяр		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
33	Хойморын худаг	С.Эрдэнэсүх М.Уламбаяр		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
34	Хамрын хажуу	Т.Гансүх Д.Буд Д.Баатархүү		Өвлийн улиралд ашиглана	
35	Хамрын хажуу	Т.Гансүх Д.Буд Д.Баатархүү		Өвлийн улиралд ашиглана	
36	Хамрын хажуу	Т.Гансүх Д.Буд Д.Баатархүү		Өвлийн улиралд ашиглана	
37	Худаг	Х.Мөнхжаргал Б.Ганбаатар		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
38	үүд зүүн	У.Элдэвсайхан У.Элбэгзаяа		Хавар, намар, зуны улиралд ашиглана	

№	Худгийн нэр	Эзэмшигчийн нэр	Гаргасан огноо	Ашиглалт	Тайлбар
39	үүд баруун	Б.Сүх-Очир Ш.Эрдэнэ-Билэг, Г.Хүрэлбаатар		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
40	Цагаан булаг	О.Ганхуяг, Ж.Баттөр		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
41	Цагаан булаг Баруун	С.Амарсайхан С.Зоригоо		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
42	Шар оноо	Ж.Хүрэлодон Д.Мөнхсүх		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
43	Ар шанд	М.Мөнхбат		Хаврын улиралд ашиглана	
44	Хар булан	Х.Сүхбаатар		Хаврын улиралд ашиглана	
45	Бичигт	Д.Бор Б.Төмөрбаатар, Б.Төмөрдаваа		Зун, намрын улиралд ашиглана	
46	Энгэр хамар	Ч.Энхбаатар, З.Мөнхбат		Хаврын улиралд ашиглана	
47	Дэрст хамар	Б.Амаржаргал, Б.Сүхбаатар		Хаврын улиралд ашиглана	
48	Дайчин хамар	Г.Доржсүрэн		Хаврын улиралд ашиглана	
49	Далай хамар	Э.Хүрэлбаатар Ц.Бор		Хаврын улиралд ашиглана	
50	өндөр хамар	Л.Даланчулуун		Хаврын улиралд ашиглана	
51	Адгийн хамар	Ц.Дашням Л.Борхүү,		Хаврын улиралд ашиглана	
52	Мухар	С.Гончигсүрэн С.Энхбат Ж.Баяраа, Д.Сумъяажав Б.Чулуунбаатар		Өвлийн улиралд ашиглана	
53	өндөр хошуу	С.Дорж, С.Мөнхбат		Өвлийн улиралд ашиглана	
54	Хорио	Б.Хүрэлчулуун, С.Ганболд Б.Сүхочир		Өвлийн улиралд ашиглана	
55	Бошго	С.Банди, Б.Чулуунбат		Өвлийн улиралд ашиглана	
56	Дэдий	М.Энхтайван		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
57	Урт гуу	Ч.Төмөр, Ч.Хүрэлбаатар		Хавар, намар, зуны улиралд ашиглана	

№	Худгийн нэр	Эзэмшигчийн нэр	Гаргасан огноо	Ашиглалт	Тайлбар
58	Бригад	Ай.Очирбат		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
59	Улаан нуур	Ж.Хутаг-өлзий		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
60	Урд хөөвөр	С.Гомбосүрэн, М.Өлзийтөгс		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
61	Аман ус	Г.Нямцэрэн Н.Очирбат		Хаврын улиралд ашиглана	
62	Хошмог	Б.Мягмарсүрэн Б.Адьяа		Өвлийн улиралд ашиглана	
63	Олон мод	Б.Энхбат С.Төмөр Л.Жавзмаа		Өвлийн улиралд ашиглана	
64	Нарийн хоолой	М.Бадамжунай Б.Ганбат Б.Гантөмөр		Өвлийн улиралд ашиглана	
65	Бууралдай	Г.Энхбаяр		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
66	Лүүт	Г.Гонгор, Г.Уржинбадам		Хаврын улиралд ашиглана	
67	Их Бургас	Б.Нацагдорж Х.Ганхуяг		Хаврын улиралд ашиглана	
68	Аман ус	А.Баяраа		Хаврын улиралд ашиглана	
69	Дайчин хамар	Г.Доржцэрэн		Зун, намрын улиралд ашиглана	
70	Лууяа	Б.Сэргэлэн		Хаврын улиралд ашиглана	
71	Улаан нуур	Н.Баянмөнх		Өвлийн улиралд ашиглана	
72	Хэрээ бүдүүн	Ч.Мөнхбаатар, Н.Азжаргал		Өвлийн улиралд ашиглана	
73	Өвдгийн тойром	Г.Хуягтбаатар		Хавар, намар, зуны улиралд ашиглана	
74	Ламтын худаг	8-р застав		Өвлийн улиралд ашиглана	
75	Тал булаг	Д.Бямбасүрэн		Өвлийн улиралд ашиглана	

Зураг 17. Гадаргын усны зураг



Хуудас 51

2.7. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

2.7.1. Инженер геологийн нөхцөл

Сүхбаатар аймгийн Дарьганга сум нь Кайнозой, Мезозой, Палеозой эринйи Дөрөвдөгч, Неоген, Палеоген, Цэрд, Перм, Карбоны галавын гүний, бялхмал чулуулгууд тархсан байна. Шавранцар, шавар, Элсээр чигжигдсэн сайр, сайрга, хайрга агуулсан элсэнцэр, шавранцар, жижиг-дунд ширхэгтэй элс зэрэг сэвсгэр хурдасаа хучигдсан ба суурь чулуулагт боржин, андезит, диорит, боржин-диорит, базальт, занар, гнейс, габброидын формацуудад ялгасан байна.

Сэвсгэр хурдсанд

Кайнозой /KZ/ хурдас:

Орчин үеийн, Дунд-Дээд Дөрөвдөгчийн настай:

- голын гаралтай – элс, хайрга, хайрганцар шавранцар, наанги элсэнцэр, хужир, давс, асга, сайрга, бул чулуу, палеолит, неолитын чулуун зэвсэг, ваар, шаазан, соёлт үе, хөхтөн амьтаны чулуужсан
- салхины гаралтай нуурын гаралтай – элс, хайрга, хайрганцар, шавранцар, наанги элсэнцэр, хужир, давс, асга, сайрга.
- алюви, голын гаралтай - элс, хайрга, шавранцар, шавар, наанги, элсэнцэр, хужир, давс, асга сайрга.
- элюви, сэвхүүлийн гаралтай – элс, хайрга, хайрганцар шавранцар, наанги элсэнцэр.
- элюви, элсэнцэр сайрга, хайрганцар, шавранцар, бул хайрга.
- пролювийн гаралтай. Бэл хормойн хаяалдас хайрганцар, элс, элсэнцэр, бул чулуу

Неогений плиоцений настай:

- Бялхмал чулуулаг – дээд плиоцен. Шүлтлэг хүрмэн, трахибазальт, базанит, хүрмэн хашигт, шаарга, нецелинт хүрмэн.
- Миоцены тунамал чулуулаг – дунд, дээд миоцен-доод плиоцен. Цайвар ногоон, саарал, цайвар, цагаан наанги, боргилт, цэрд, хайрга, элс, заримтдаа дээд хэсэгтээ улаан наанги, элсжин, занууу боргилтын зузаалагтай.

Палеогены настай:

- Тунамал чулуулаг – дунд-дээд олигоцен. Улаан, улаан хүрэн, эрээн наанги, занууу, явар боргилтын цолмон, мэшил, үенцэр болон, марганцарын буурцган үрэл, шигтгээтэй наанилаг хурдас

Мезозой /MZ/ хурдас:

Дээд цэрдийн галавын: Тунамал чулуулаг. Дээд-сеноман-доод сантон. Улаан, улаан ягаан, эрээн наанги, боргилт, элсжин, занууужин, элсэрхэг наанги, явар, хөрзөн. Баянзагын төрлийн үлэг гүрвэлийн өндөг.

Доод цэрдийн галавын: Бялхмал чулуулаг. Хүрмэн, андезит-хүрмэн, трахиандезит, риолит, трахириолит, перлит, тэдгээрийн бөслүүд бөсөлжин, элсжин, хөрзөн, боргилт, наангинцар, занууужин, наангилаг, занар, боргилтлог занар.

Палеозой /PZ/ хурдас:

Доод карбон галавын: Бялхмал чулуулаг. Элсжин, андезит-пофирит, бөсөлжин, занууужин, наангинацар, элсэрхэг явар, шохойжин.

<u>Гүний чулуулаг</u>

Палеозой. /PZ/

Түрүү пермийн галавын: Гүний чулуулаг /интрузив/. Андезит-порфирит, андезит-дацит, трахириолит, риодацит тэдгээрийн бөслүүд, бөсөлжин, хөрзөн, занууужин, элсжин.

Дунд-Дээд карбон галавын: Гүний чулуулаг /интрузив/ . Боржин бүрдэл.

Зураг 18. Инженер геологийн нөхцлийн тойм зураг



Хуудас 54

2.7.2. Геоморфологийн тогтоц

Геоморфологийн тогтоцийн хувьд галт уулын гаралтай бялхмал бэгэлцэг – хярын гадаргуу зонхилно.

Аман ус, овоот багийн нутаг дэвсгэрээр ихэвчлэн тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулс дотоодын хотгор дахь элэгдлийн гаралтай өргөгдмөл хотгор гүдгэр - Ул чулуулаг дээрх элэгдлийн суурьт тал долгиот гадаргуу зонхолсон байна.

Дунд ба шинэ төрмөлийн эриний сул барьцалдсан чулуулаг дээрх элэгдлийн давхаргат тал – хангайдуу ба долгиот, ялимгүй сэргэж хэлбэршсэн, нэн хуурайшмал, тэгшрэлийн гадарга бүхий үлдмэл уул (хяр, зоо) – сул хэрчигдэлтэй хярласан үлдмэл нам уулс, тэгширмэл газар, уул хоорондын ба уулс дотоодын хотгор, голын хөдий дэх хурмал хурдаст гадарга алювийн тэгш тал – орчин үеийн татам, сайрын хөндий ба ёроол, нуурын хурдас тал – нуурын хэв төрх нь сайн хадгалагдаж үлдсэн хэрчигдэлгүй дэнж, алюви-пролювийн тал, салхины үйлдлээр үүссэн элсэн хуримтлал бүхий тал – салхины үйлдлээр үүссэн элсэн хуримлал бүхий тал зонхилсон геоморфологийн тогтоцтой байна. Нутгийн ихэнх хэсгээр 1000-1400 метрийн үнэмлэхүй өндөртэй бадрах болон аман ус багийн зүүн урьд хэсгүүдээр ерөнхийдөө өндөршилт ихтэй 1600 метрээс дээш өргөгдөн тогтсон байна. Ихэвчлэн гадаргуугийн хэвгий 0-6 градусын хооронд байна. Галт уулын үлдэгдэл, эрэглэсэн хажуу, уулс орчимоор 6-12 градусын гадаргуугийн хэвгийтэй байна.

Зураг 19. Геоморфологийн тогтоц



2.7.3. Газар чичирхийлэл

Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 6 баллын газар хөдлөлийн бүсэд орж байна.

Зураг 20. Газар хөдлөлтийн мужлалын зураг



2.7.4. Гидрогеологийн нөхцөл болон цэвдгийн тархалт

Сүхбаатар аймгийн Дарьганга сум нь гидрогеологийн өмнөд системийн Дорноговь болон сүүж нуурын ай савд багтдаг. Дарьганга сумын нутаг нь биеэ даасан намхан уулс, жигд үргэлжилсэн толгодоос болон тэдгээрийн намсаж доошилсон хэсэг болох тал хөндийгөөс ээлжлэн тогтсон бөгөөд Дорноговийн ай савын зүүн урд үзүүрийн хамгийн өндөр цэг болдог далайн түвшнээс дээш 1778 м өргөгдсөн Шилийн богд уул, 1348.8 м үнэмлэхүй өндөртэй Дарь уул буюу Алтан овоо уул зэрэг байгалийн өвөрмөц, түүх дурсгалт тогтоцуудтай. Дарьганга сумын төвийн өмнөт талын жигүүрт зүүн урд талаасаа хойш чиглэлд олон арван км сунаж тогтсон “Онгон-Молцог” хэмээх элсэн манхан нуруу байдаг. Энэхүү элсэн манхан нурууны өргөний хэмжээ дунджаар 10 орчим км байна. Бүс нутгийн зарим хэсэгт шинэ болон дунд төрмөлийн үеийн (кайнозой-мезозойн) сөнөсөн галт уулсын бүс нилээд элбэг байдаг тул гадрагын хэв шинж ихэнхи тохиолдолд огцом өөрчлөгдөж ихээхэн хэрчигдэлд орсон байна /зураг 20/.

Усзүйн гадаргын сүлжээний хувьд Мэнэнгийн талын сав, Галба-үүш-Долоодын говийн сав газруудад хамаарагдах ба томоохон гол мөрөн байхгүй, харин бэсрэг ил задгай гадаргын урсац, булаг шанд, жижиг нуур харьцангуй элбэг тохиолддог. Тухайлбал Дарьганга сумын төвийн орчимд газрын доорх усны илрэл болсон-Дагшин, Өргөн, Их, Тал, Ар, Хамар зэрэг цэнгэг булгууд, Алтан Овоо уулын баруун урд бэлд Дуут, Зэгст хэмээх харьцангуй шорвог устай нуурууд тус тус байдаг. Тэдгээр нуурыг Дагшин булгаас эх авсан гадаргын бэсрэг ил задгай урсац тэжээхээс гадна манхан элсэнд бүрлдэн бий болдог конденсацийн газрын доорх усны алсын урсацаар тэжээгдэх боломжийн нөхцөлтэй.



Сумын төвийн өмнөт хэсгээр зүүн урдаасаа баруун хойшоо сунаж тогтсон 10 км орчим өргөнтэй элсэн манхан нурууны хойт хаяагаар дээр дурьдсан олон тооны булгууд гарч байгаа ба тэдээгрийн элсэн манханы дотор үүсэж хуримтлагдсан газрын доорх усны алсын урсац тэжээдэг. Элсэн манханы хойт хаяа орчмын зурвас хэсэг нь газрын доорх усны хөлийн бүс болж байна. Сэвхүүл элсын уст давхраас нь чөлөөт гадаргатай нүх сүв давхаргын ус агуулсан байх бөгөөд энэхүү уст давхраас элсэн манхануудын хоорондох хотгорт 1-10 м гүнд илрэх ба сэвхүүлс элсний булгуудын өнгөрөлт 0.1-1л/с-ийн хооронд зонхилж өөрчлөгдөх боловч зарим тохиолдолд 4-80 л/с хүрдэг. Сэвхүүл элс доторх газрын доорх ус 0.2-0.6 г/л эрдэсжилтэй, гидрокарбонат, гидрокарбонат-сульфат, гидрокарбонат-хлорид, натри, натри-кальци, кальци-магнийн найрлагатай. Зарим уст цэгүүдэд нитрит төмөр илэрдэг.

Цэвдгийн тархалт: олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын маягаар тархсан байхан бадрах болон аман ус багуудын нутаг тааралдана. Бусад хэсгээр улирлын цэвдэг чулуулаг үүсэх бүслүүрт хэсэг зонхилсон байна. Олон жилийн цэвдэгт бөөргүүд ба цэвдэгт сондуулууд бадрах багийн нутагт зарим хэсгүүдэд тааралдана. /Зураг - 21/

Хүснэгт 20. Сумын олон жилийн цэвдэгийн тархалт

Д/д	Цэвдгийн тархалт	Талбай, га	Эзлэх хувь, %
1	Олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалт	300521.7	62.52
2	Улирлын цэвдэг чулуулаг үүсдэг бүслүүр	180124.65	37.48

Зураг 21. Цэвдгийн тархалтын зураг



III. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

3.1.1. Түүхэн хөгжлийн тойм.

Манжийн хаанаас 1696 онд явуулсан өөрчлөлтөөр өөрийн 5 гар хожим нь Дарьганга хошуу гэж нэрлэгдэх болж, мал сүргийг төвлөрүүлснээр Дарьганга хэмээх сүрэгчин хошуу бий болсон байна. 1924 оноос эхлэн Дарьгангын сүргийн хуучин 5 гарыг өөрчлөн засаг захиргааны дотоод зохион байгуулалт хийж, Дарьганга уулын хошууг 18 сумын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, нутгийн дүрмийг баталж гаргажээ. Улсын бага хурлын 1925 оны 5 дугаар тогтоолоор Дарьганга хошуу нь 17 багтайгаар Дагшин булаг, Молцог, Нартын уул сумдаас шинээр Дарьганга сум байгуулагджээ.

Угсаатан зүй: Дарьгангачууд нь Сүхбаатар аймгийн нутгийн баруун өмнө хэсгийн 6-н суманд оршин суух бөгөөд анхны нутагласан газар болох Дарь овоо, Ганга нуурын нэрээр Дарьганга гэж нэрлэгдсэн улс юм. Дарьганга хүмүүс нь угтаа 1690-ээд оны сүүлчээр халх Монгол Манжийн захиргаанд орох үест Манжийн хааны төмөр сүргийг адуулгахаар цахар, халх, ойрадаас хүдэр чийрэг мал маллагаанд гаргууд хүмүүсийг татаж халхын Түшээт хан аймгийн говь Мэргэн вангийн хошуу, Сэцэн хан аймгийн хурц вангийн хошууны дунд суулгасан сүрэгчин хүмүүс болно. Эдгээр хүмүүс олон жилийн турш холилдон уусч өөр бусад хэсгийн хүмүүсээс ялгагдах өөрийн соёл буюу хувцас хунар, гоёл чимэглэл, найр хуримын ёс дэг зэрэг эд материал соёлын талаар бага зэргийн өвөрмөц ялгааг бий болгосон учир өөр нэг ястан гэж авч үзэх болжээ.

3.1.2. Хүн амын одоогийн байдал

Тус сум нь 2015 оны байдлаар 2994 хүн ам, 871 өрх айл байгаагаас нийт хүн амын 58.72 хувь нь буюу 1758 хүн сумын төвд, 41.28 хувь буюу 1236 хүн хөдөөд амьдарч байна. Сумын хүн амын нягтшил 0.62 хүн/км.кв байгаа нь Сүхбаатар аймгийн бусад сумуудтай харьцуулахад нягтшил өндөр байна.

Хүснэгт 21. Сумын хүн амын тоо /сүүлийн 3 жилээр/

Хүн амын үзүүлэлт		Хугацаа, оноор										
		2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Сумын нийт хүн ам		**2872**	**2940**	**2913**	**2884**	**2853**	**2883**	**2846**	**2856**	**2852**	**2897**	**2994**
Үүнээс	Сумын төвийн хүн ам							787	1013	1268	1292	1758
	Хөдөөгийн хүн ам							2059	1843	1584	1605	1236
Нийт өрхийн тоо		**763**	**787**	**778**	**803**	**798**	**808**	**792**	**807**	**828**	**844**	**871**
Үүнээс	Төвийн өрх							238	302	382	390	521
	Малчин өрх							554	505	446	454	350

Төрөлт, 1000 хүнд ноогдох							62	63	57	52	74
Нас баралт, 1000 хүнд ноогдох							31	16	20	24	11

Диаграмм 9. Сумын хүн амын тоо, сүүлийн 10 жилээр



Багуудаар харьцуулж үзэхэд Овоот багийн нутагт сумын төв байрладаг бөгөөд хамгийн их буюу 1113 хүн амтай хэдий ч хүн амын нягтшилаар 1 км.кв талбайд 1.6 хүн ноогдож байна. Харин хамгийн их газар нутгийг хамарсан Бадрах баг 645 хүн амтай, 0.40 хүн/км.кв нягтшилтай байна.

Хүснэгт 22. Сумын хүн амын үзүүлэлт, багуудаар

Багийн нэр	*Хүн амын тоо*	*Хүн амын нягтшил, хүн/км.кв*	*Өрхийн тоо*
1-р баг, Үүд	645	0.40	177
2-р баг, Бадрах	703	0.36	190
3-р баг, Аман-Ус	533	0.95	160
4-р баг, Овоот	1113	1.60	344
Сумын нийт	2994	0.62	871

Диаграмм 10. Сумын хүн ам, өрхийн тоо, багуудаар



3.1.3. Мал, аж ахуйн судалгаа

Сумын хэмжээгээр нийт 38227 толгой мал байгаагаас 42.13 хувийг хонь, 29.80 хувийг ямаа, 12.85 хувийг үхэр, 15.16 хувийг адуу, үлдсэн 0.06 хувийг тэмээ эзэлж байна.

Хүснэгт 23. Сумын малын тоо, төрлөөр, 2015 он

Баг/хороо	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1-р баг, Үүд	5 527	690	705	5	2 515	1 612
2-р баг, Бадрах	4 540	900	337	4	1 863	1 436
3-р баг, Аман-Ус	5 369	864	731	10	1 930	1 834
4-р баг, Овоот	22791	3342	3138	4	9797	6510
Сумын нийт	**38 227**	**5 796**	**4 911**	**23**	**16 105**	**11 392**

Сүргийн бүтцийн хувьд ямааны эзлэх хувь 29,8 хувьтай байгаа нь тохиромжтой үзүүлэлт бөгөөд цаашид уг бүтцийг хэвээр нь хадгалах шаардлагатай болно.

Диаграмм 11. Сумын малын тоо, багаар



Хүснэгт 27 . Сумын малын тооны өөрчлөлт, сүүлийн 10 жилээр

Мал төрөл	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Адуу	12680	10834	8975	9254	11324	12737	13537	14455	16614	18275
Тэмээ	513	414	353	367	432	452	373	299	240	241
Үхэр	10815	9234	8689	9479	12484	12321	13218	14448	15739	17185
Хонь	57504	51935	48676	55732	64638	62447	64983	69105	78815	89021
Ямаа	36464	37184	35630	41359	44885	43314	45087	44301	51250	57954
Сумын нийт	**117976**	**109601**	**102323**	**116191**	**133763**	**131271**	**137198**	**142608**	**162658**	**182676**

Сүүлийн 10 жилийн байдлаар сумын хэмжээнд тэмээний тоо толгой буурч, хонь, ямаа, адуу, үхэрний тоо толгой өссөн байна.

Диаграмм 12. Сумын малын тооны өсөлт, төрлөөр









IV. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ ЭДЭЛБЭРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

4.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН

Дарьганга сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг солбицолжуулах, баталгаажуулах ажлыг 2012 онд Газар дэлхий ХХК гүйцэтгэсэн ба солбицлын тусгагийн зөрүүнээс үүдэн аймаг, сумдын хилийн цэсийн талбайн хэмжээнд өөрчлөлт орж, 0,35 га-аар талбай нь нэмэгдсэнээр одоогийн сумын нийт талбай 480828.93 га болсон.

Хүснэгт 24. Сумын газрын нэгдмэл сангийн ангилалын талбайн зөрүү /га/

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал	Хөдөө аж ахуйн газар	Хот тосгон бусад суурин газар	Ойн сан бүхий газар	Усны сан бүхий газар	Зам шугам сүлжээний газар	Улсын тусгай хэрэгцээний газар	Нийт
Газрын нэгдмэл сангийн тайлангаар	325931.13	342.57	0.44	911.74	517.32	153126.07	480829.28
Хэмжилтээр	338112.04	148.06	1889.34	1028.74	1468.66	138182.09	480828.93
Зөрүү	-12180.90	194.51	-1888.90	-117.00	-951.35	14943.98	0.35

Сумын нийт талбайн 70.31 хувь буюу 338112.0 га нь хөдөө аж ахуйн газар, 0.03 хувь буюу 148.06 га талбайг хот тосгон бусад суурин газар, 0.3 хувь буюу 1468.66 га талбайг зам, шугам сүлжээний газар бүхий газар, 0.39 хувь буюу 1889.34 га талбайг ойн сан бүхий газар, 0.21 хувь буюу 1028.74 га талбайг усан сан бүхий газар тус тус эзэлж байна.

Диаграмм 13. Дарьганга сумын газрын нэгдмэл сангийн ангилал



Зураг 22. Газар нэгдмэл сангийн зураг



4.2. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Дарьганга сум нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэлт зонхилдог учир нийт нутаг дэвсгэрийн 95.99 хувийг бэлчээрийн зориулалтаар ашиглаж байна.

Хүснэгт 25. Сумын газар ашиглалтын талбай

Үндсэн ангилал	Ангиллын түвшин 1	Ангиллын түвшин 2 /ашиглалтын зориулалт/	Талбайн хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	Бэлчээр	өвөл-хаврын	339688.03	70.646
		зун-намрын	121921.66	25.357
	ХАА-н барилга, байгууламжийн газар	өвөлжөө, хаваржаа	268.73	0.056
		бэлчээр дэх уст цэг	49.02	0.010
Хот, тосгон, бусад суурины газар			309.26	0.064
Зам, шугам сүлжээний газар	Авто замын газар	сайжруулсан шороон зам	1043.89	0.217
		ердийн шороон зам	417.79	0.087
	Шугам, сүлжээний газар	холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах станц, шугам	124.05	0.026
		эрчим хүч, дамжуулах шугам, станц	31.78	0.0066
Ойн сан бүхий газар	Ой модоор бүрхэгдсэн газар	ой модоор бүрхэгдсэн	14966.47	3.113
	Ой модоор бүрхэгдээгүй газар	ой тэлэн ургах нөөц газар	1.47	0.0003063
Усны сан бүхий газар	Булаг	Булаг	0.25	0.0000529
	Нуур	Нуур	2006.52	0.417
Сумын нийт			480828.93	100.000

Зураг 23. Одоогийн газар ашиглалтын зураг



4.2.1. Бэлчээр ашиглалт

Сумын хэмжээгээр нийт 588 өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байгаагаас 123 нь 2 улирал, 465 нь 1 улирлаар ашиглагдаж байна. /Зураг 25/

Хүснэгт 26. Өвөлжөө, хаваржааны тоо.

Баг	Талбай, га	Бэлчээр
Үүд баг	43285.31	Өвлийн бэлчээр
	21821.55	Өвөл, хаврын бэлчээр
	54199.97	Хаврын бэлчээр
	37372.43	Хавар, намар, зуны бэлчээр
Бадрах баг	136254.79	Өвлийн бэлчээр
	50393.16	Зун, намрын бэлчээр
	10068.98	Өвөл, хаврын бэлчээр
Аман ус баг	33408.54	Өвлийн бэлчээр
	20362.77	Хаврын бэлчээр
Овоот баг	34851.89	Өвлийн бэлчээр
	38021.84	Хавар, намар, зуны бэлчээр

Сумын хэмжээнд уламжлалт мал аж ахуй эрхэлдэг бөгөөд малын төрлүүдээс хонийг голчлон өсгөж байгаа нь бэлчээрийг эрчимжсэн хэлбэрээр бус улирлын аясыг даган нүүдэллэх маягаар зохицуулалттай ба зохицуулалтгүй ашиглах аргыг хэрэглэж байгаа нь судалгаагаар илэрч байна.

Зураг 24. Малчдын дөрвөн улирлын байршлын зураг



Хуудас 68

4.2.2. Бэлчээрийн даац

Сумын хэмжээгээр Овоот багийн бэлчээрийн даац 2 дахин, Аман-Ус багийн бэлчээрийн даац 1 дахин хэтэрсэн бөгөөд Үүд, Бадрах багийн бэлчээрийн даац хэтрээгүй байна.

Хүснэгт 27. Сумын бэлчээрийн даац, багаар

Багийн нэр	*Малын тоо /хонин толгой/*	*Талбай /га/*	*Га-ийн ургац /цн/*	*Тэжээлийн нөөц, цн*	*Жилд идэх өвс /цн/*	*Багтаамж /хонин толгой/*	*Даац /хувь/*
1-р баг, Үүд	49,130	159465.6	4.71	751083.2	6	125180.5	94.10
2-р баг, Бадрах	51,541	195914.4	4.69	918838.7	6	153139.8	81.17
3-р баг, Аман-Ус	31,871	56010.17	4.94	276690.2	6	46115.04	188.90
4-р баг, Овоот	50,134	69438.49	4.42	306918.1	6	51153.02	207.63

Зураг 25. Бэлчээрийн даацын зураг /багаар/



4.2.3. Хадлангийн газрын ашиглалт

Тус сумын хувьд малчин өрхүүд өөрсдийн хэрэгцээний хадлангаа 2015 онд Бадрах багийн бэлчээрээс бэлтгэсэн байсаныг Landsat8 хиймэл дагуулын мэдээ ашиглан тодорхойлж зурагт үзүүлсэн бөгөөд баталгаажсан болон тогтоосон хадлангийн талбайгүй бөгөөд малчид бэлчээр орчмын газраасаа хадах буюу худалдан авдаг байна.

Зураг 26. Хадлангийн газрын ашиглалтын зураг



4.2.4. Ойн сан бүхий газрын ашиглалт

Сумын хэмжээнд ойгоор бүрхэгдсэн газар нийт нутгийн 13.46 хувийг эзэлдэг бөгөөд бургас, тармаг хайлаас, торлог зонхилдог.

Хүснэгт 28. Ойн төрөл, талбайгаар

Д/д	Ойн төрөл	Талбай, га
1	Дунд насны бургас	48.43
2	Залуу бургас	424.95
3	Ойжуулсан талбай	1.47
4	Тармаг хайлаас	12972.58
5	Торлог	1545.62

Зураг 27. Ойн төлөв байдлын зураг



4.2.5. Уул уурхайн ашиглалт

Сумын хэмжээнд 2 хайгуулын талбай байгаа бөгөөд уг талбай нь Үүд, Овоот багийн нутаг Шүүт, Дунд Нарт хайгуулын талбай байна. Уг талбай нь хэмжээ 93793.74 га байна.

Хүснэгт 29. Хайгуулын талбайн мэдээлэл

Д/д	Газрын нэр	Гэрчилгээ олгосон хугацаа	Зөвшөөрөл дуусах хугацаа	Талбай, га
1	Шүүт	7/22/2008	7/22/2017	38364.52
2	Дунд нарт	8/18/2008	8/18/2017	55429.22

Зураг 28. Уул уурхайн ашиглалтын зураг



4.2.6. Аялал жуулчлалын газрын ашиглалт

Сумын хэмжээнд зөвшөөрөлтэй 6 аялал жуулчлалын бааз үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Хүснэгт 30. Аялал жуулчлалын баазын мэдээлэл

Д/д	Амралт сувилалын газар	Үйл ажиллагаа эрхлэгчийн нэр	Хүчин чадал	Утас
1	Талын агуй жуулчны бааз	М.Амгалан	60 ор, 1 байшин, 7 гэр	99261659, 96091659, 11812561
2	Шилийн богд жуулчны бааз	Батхүрэл	9 гэр, 39 ор	91033140, 99690976
3	Хөх тэнгэрийн зам жуулчны бааз	Эрдэнэцогт	10 байшин, 3 гэр, 1 хоолон гэр	91912208, 91227927
4	Дагшин булаг жуулчны бааз	Баттөр	3 байшин, 3 гэр, 30 ор	95043299
5	Нью Дарьганга амралтын газар	Буд	6 байшин, 5 гэр	99032208, 91002208
6	Гангар хун жуулчны бааз	Л.Энхцэцэг	10 гэр, 5 байшин	99170299, 96040696

Зураг 29 Аялал жуулчлал, амралт сувиллын байршлын зураг



4.3. ГАЗАР БОЛОН БАЙГАЛИЙН НӨӨЦ

4.3.1. Бэлчээрийн газрын чадавхийн болон эдийн засгийн үнэлгээ

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын бэлчээрийн чадавхийн зургыг зураглахдаа 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн “Ландсат 8” хиймэл дагуулын 2 сценэ мэдээг татаж авч ашигласан болно. Хиймэл дагуулын мэдээнд Erdas Imagine, ENVI програм хангамжийг ашиглан боловсруулалт хийв. Бэлчээрийн чадавхийн байдлаар ангилан зураглахдаа ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/104 тушаалын хавсралтаар батлагдсан “Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварыг ашиглах зөвлөмж”-ийн дагуу монгол орны байгалийн бүс, бүслүүр бүрээр ангилсан 25 төрлийн бэлчээрийн ангиллыг ашиглаж, ArcGIS програм хангамжаар зурагласан. /Зураг 30/

Сүхбаатар аймгийн Дарьганга сум нь Монгол орны хуурай хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд хөнгөн шавранцар, чулуурхаг, зузаан элсэн зэрэг хөрстэй, уулын бэл хөндий, орой, энгэр, тэгшивтэр тал хөндийн бэлчээр зэрэг 5 төрлийн бэлчээрт хуваагдаж байна. Бэлчээрийн ангиллын талбайн хэмжээг доорхи хүснэгтээр харуулав.

Хүснэгт 31 Бэлчээрийн талбайн хэмжээ ангилал тус бүрээр

№	Бэлчээрийн ангилал	Талбайн хэмжээ /га-аар/
1	Чулуурхаг хөрстэй уулын орой болон энгэр хажуугийн крыловын хялгана-үетэн-алаг өвст бэлчээр	71578.59
2	Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн том хялгана-түнгэ-алаг өвст бэлчээр	186546.97
3	Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн крыловын хялгана-хазаарт өвст бэлчээр	180670.99
4	Зузаан элсэн хөрстэй тэгшивтэр тал хөндийн харгана-үетэнт бэлчээр	47770.93
5	Хөрсний гүний ус ойрхон дэрст цайдам бүхий бэлчээр	1504.61

Бэлчээрийн чадавхийн зургаас харахад Дарьганга сумын нутаг дэвсгэрийн зүүн хэсгээр чулуурхаг хөрстэй уулын орой болон энгэр хажуугийн крыловын хялгана-үетэн-алаг өвст бэлчээр, төв, зүүн, урд хэсгээр хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн том хялгана-түнгэ-алаг өвст бэлчээр, баруун хойд, хойд, урд хэсгээрээ хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн крыловын хялгана-хазаарт өвст бэлчээр, баруун захаараа зузаан элсэн хөрстэй тэгшивтэр тал хөндийн харгана-үетэнт бэлчээр, нууруудын ойр орчимд хөрсний гүний ус ойрхон дэрст цайдам бүхий бэлчээр зонхилж байна.

Зураг 30. Дарьганга сумын бэлчээрийн чадавхийн зураг, 2015 оны байдлаар



4.3.1.1. Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ

ГХГЗЗГ, УЦУОСМХ, ШХА, Ногоон Алт төслөөс хамтран боловсруулсан “Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд, зөвлөмжөөс харахад Дарьганга сумын бэлчээрийн газар нь газрын гадаргын тогтоц, хөрс уур амьсгалын нөхцлөөрөө хуурай хээрийн бүслүүрийн 1) хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн том хялгана-түнгэ-алаг өвст бэлчээр, 2) хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн крыловын хялгана-хазаар өвст бэлчээр гэсэн 2 бүлэгт хуваагдаж байна. Үүнд.

1. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн том хялгана-түнгэ-алаг өвст бэлчээр

Энэхүү бэлчээр нь манай оронд д.т.д 661-1300 м өндөр бүхий ухаа гүвээт болон тэгш тал, заримдаа нам уулсын хажуу, бэл хормой, өргөн хөндийгөөр тархана. Энэ төрлийн бэлчээрийн төлөв байдал нь унаган төрхөөсөө нилээд өөрчлөгдсөн том хялганы сэргэлтийг дэмжихийн тулд бутлалтын болон үр боловсрох үеэр бэлчээрийг аль болох чөлөөлөх шаардлагатай. Аль болох хөнгөн ашиглах, ачааллыг бууруулах зорилгоор энгийн хуваарьтай ашиглалтыг нэвтрүүлнэ. (Зураг 31)

Зураг 31. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн том хялгана-түнгэ-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар.



2. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн крыловын хялгана-хазаар өвст бэлчээр

Энэхүү бэлчээр нь Монгол орны хамгийн өргөн тархац бөгөөд ихэнх аймгуудын нутагт тааралдана. Ихэнхдээ уулсын хөндий, бэл хормой, тал газрыг эзлэн орших бөгөөд нам уулс, цав толгодын хажуу, бэл хормойгоор д.т.д 925-1980 м өндөрт тархдаг. Энэ төрлийн бэлчээрийн төлөв байдал нь унаган төрхөөсөө нилээд өөрчлөгдсөн крыловын хялганы сэргэлтийг дэмжихийн тулд 1. Энгийн хуваарьтай ашиглалтыг нэвтрүүлэх, өөрөөр хэлбэл бэлчээрээ 5-7 хэсэгт хувааж шон, чулуун овоо босгох, эсвэл байгалийн таних тэмдэг ашиглан ээлжлэн ашиглах, үүний тулд байнгын хариулга зайлшгүй чухал. Энгийн хуваарьтай ашиглалтыг нэвтрүүлсэнээр бэлчээрийн ачааллыг 10-25 хувиар бууруулах боломжтой. 2. Бутлалтын болон үр боловсрох үеэр бэлчээрийг аль болох чөлөөлөх зорилгоор 2 талбайт сэлгээг нэвтрүүлэх шаардлагатай. 3. Бэлчээрийн хүрэлцээтэй нөхцөлд 1 зуны турш ашиглалтаас чөлөөлөх үр дүнтэй. (Зураг 32).

Зураг 32. Хөнгөн шавранцар хөрстэй уулын бэл хөндийн крыловын хялгана-хазаар өвст бэлчээрийн төлөв байдлын загвар.



Зураг 33. Дарьганга сумын малын тоог бэлчээрийн даацад харьцуулах нь



4.3.1.2. Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй

Бэлчээрийн газрын суурь үнэлгээг тооцохын тулд дараах 3 байдлаар үнэлж тооцлоо.

Үүнд:

1. Хөрсийн чанарын үнэлгээ /Хчү/
2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ /БГбчү/
3. МАА үйлдвэрлэлийн бизнес тооцооллын аргаар үнэлсэн үнэлгээ /Окү/

Дээрх 3 үнэлгээгээр бэлчээрийн газрын суурь үнэлгээ/Гсү/ гарах юм.

$$Гсү = Хчү + БГбчү + МААб$$

Нэг. Хөрсийн чанарын үнэлгээ

4.3.1.3. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ, бэлчээрийн багтаамжийг тооцох

Хүснэгт 32. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац(в)-ыг дараах хүснэгтээр тооцно.

Багийн нэр	Бэлчээрийн талбай /га/	1 га-гийн ургац /цн/	Нийт ургац /цн/
1-р баг, Үүд	159465.8	4.71	751084.1
2-р баг, Бадрах	195914.4	4.69	918838.7
3-р баг, Аман-Ус	56010.14	4.94	276690.1
4-р баг, Овоот	69438.55	4.42	306918.4
Нийт	**480828.95**		**2253531.22**

Хүснэгт 33. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ улирал тус бүрээр

Малын төрөл	Улирал ба өвсний хэмжээ /кг/			
	Зун	Намар	Өвөл	Хавар
Адуу	7.8	8.1	6.5	5.8
Тэмээ	14.1	13	8.4	9.9
Үхэр	8.7	9.7	7.4	7.4
Хонь	1.9	1.6	1.1	1.1
Ямаа	1.3	1.4	1	1

Бэлчээрийн газрын нийт ургацыг мал жилийн 4 улиралд идэх бөгөөд ургац зун ногоон, намар хагдарч эхлэх, өвөл, хавар хагд байдлаар мал идэгддэг билээ. Тиймээс нэг хонин толгойн жилд идэх ургацыг дараах байдлаар тооцно.

$$a1 = \frac{Н*НМз}{100},\ \ a2 = \frac{Н*НМн}{100},\ \ a3 = \frac{Н*НМөх}{100},$$

а1-нэг хонин толгойд идэгдэх ургац /Зун/
а2-нэг хонин толгойд идэгдэх ургац /Намар/
а3-нэг хонин толгойд идэгдэх ургац /Өвөл, хавар/
Н-ногоон масстай байх хонгийн тоо
НМ- нэг өдөр идэх ургац

$$a1 = \frac{90*1.9}{100} = 1.71\ тн,\ \ a2 = \frac{45*1,6}{100} = 0.504\ тн,\ \ a3 = \frac{230*1,1}{100} = 1.265тн,$$

$$x1 = \frac{в * a1^2}{a1^2 + a1 * a3 - a1 * a2} = \frac{2253531.22 * 2.9241}{2.9241 + 2.16315 + 0.861184} = \frac{6589550.64}{5.948434} = 1107779$$

Эндээс малд идэгдэх бодит ургац 1107779 цн

Бэлчээрийн багтаамжийг малд идэгдэх бодит ургацыг нэг хонин толгойн өдөрт идэх ургацад харьцуулж үзэхэд 1186069.06 хонин толгой болж байна.

4.3.1.4. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох.

Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$Мт = \frac{\left[\frac{АЖт}{100} + (АЖд - АЖт)\right] НГт}{100}$$

Мт-Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ

АЖд-Дараах насны малын амьдын жин

АЖт-Тухайн насны малын амьдын жин

НГ-Тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 34. Нядалгааны гарц тооцох хүснэгт

№	Малын төрөл	Нядалгааны гарц хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 35. Монгол хонины махны гарц

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузын жин /кг/	Гарц /%/
12 сартай	28.9	10.16	42.5
1.5 настай	43.78	21.07	48.13
2.5 настай	51.0	26.89	52.73
3.5 настай	58.27	32.22	55.28
4.5 настай	60.46	33.46	55.34
5.5 настай	70.95	38.75	54.61

Хүснэгт 36. Хонин сүргийн зохистой харьцаа

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	21.7	28146
2	2.5	14.4	18673
3	3.5	32.2	41656
4	Хээлтүүлэгч	0.5	606
5	Хээлтэгч	31.2	40387
	Бүгд	100	129468

Хүснэгт 37. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Нас, хүйс	Амьдын жин	Зун-намрын улиралд нэмэгдэх /нэг хонин толгойд/				Малын тоо	Бүгд нэмэгдэх
		Өвөл-хавар алдсан жин /кг/	Нас дэвших хүртлэх нэмэгдэх жин /кг/	Бүгд нэмэгдэх	Бүгд нэмэгдэл нядалгааны гарцаар		
1.5	43.8	13.1	7.2	20.3	9.7	28146	273016.2
2.5	51	15.3	7.3	22.6	10.8	18673	201668.4
3.5	58.3	17.5	2.2	19.7	9.5	41656	395732
Хээлтүүлэгч	57	17.1	14	31.1	14.9	606	9029.4
Хээлтэгч	47	14.1	13.5	27.6	13.2	40387	533108.4
Бүгд						**129468**	**1412554.4**

Дээрх хүснэгтээр тооцсон хонины махыг хонин толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$\text{Тх} = \frac{\text{АШмах} + (\textit{АШмах} * \textit{НГх})}{\text{АЖэ/х}}$$

Тх-хонины тоо, АШмах-махан ашиг, НГх-нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ($\frac{46}{100} = 0.46$),

АЖэ/х= хонины амьдын жин /дундажаар/

$$\text{Тх} = \frac{\mathbf{1412554.4} + (\mathbf{1412554.4} * 0.46)}{52.22} = 39493$$

Хүснэгт 38. Хонин толгойг сүргийн бүтцээр ангилвал дараах байдалтай байна.

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	17	28146
2	2.5	13	18673
3	3.5	33	41656
4	Хээлтүүлэгч	1	606
5	Хээлтэгч	36	40387
	Бүгд	100	129468

Хүснэгт 39. Хонины сүү бий болгох чадавхийг дараах хүснэгтээр тооцно.

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм хонь	40387	30	1211610

Хүснэгт 40. Хонины ноос бий болгох чадавхийг даарх хүснэгтээр тооцно.

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноос /кг/	Бүгд /кг/

1	1.5	28146	1	28146
2	2.5	18673	1.2	22407.6
3	3.5	41656	1.3	54152.8
4	Хээлтүүлэгч	606	1.7	1030.2
5	Хээлтэгч	40387	1.5	60580.5
	Бүгд	129468		166317.1

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн /толгой, цувдай, өлөн/ бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон 159055 тэнцүү тооны байна**.**

Хүснэгт 41. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Мах			Сүү			Ноос			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /төгрөг/
Бий болгох /кг/	Нэгжийнүнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийнүнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийнүнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийнүнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
39493	6,422.00	253624046	1211610	6,422.00	36348300	166317.1	500.00	83158550	129468	800.00	103574400	129468	2,500.00	161835000	638540296

Дээрх хүснэгтээс харахад Дарьганга сумын 480828.95 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхи 638 540 296 төгрөг болж байна.

Эндээс 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцож үзвэл

$$\text{БЧга} = \frac{\text{БЧ}}{S} = \frac{638\,540\,296 \text{ төг}}{480828.95 \text{ га}} = 1327.999 \textit{ төгрөг}$$

4.3.2. Ойн нөөц

Сумын ойн нөөц: Дарьганга сумын Аман-Ус, Бадрах сумын нутаг дэвсгэрт гол төлөв тармаг хайлаас тархсан байна. Бага хэмжээгээр бургас, торлог ургадаг байна.

Хүснэгт 42. Сумын нутаг дэвсгэрт тархсан ойн төрөл

Д/д	Ойн төрөл	Талбай, га
1	Дунд насны бургас	48.43
2	Залуу бургас	424.95
3	Ойжуулсан талбай	1.47
4	Тармаг хайлаас	12972.58
5	Торлог	1545.62

Зураг 34. Ойн төрлийн зураг



4.3.3. Тусгай хамгаалалттай газар

Дарьганга суманд улсын тусгай хамгаалалтанд авсан 3 газар, аймгийн орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан нийт 4 газар бүхий 693249.56 га талбай байна. /Зураг 35/

Хүснэгт 43. Сумын тусгай хамгаалалттай газрын ашиглалт

Д/д	Нэр	Хамгаалалтанд авсан хугацаа	Төрөл	Талбай, га	Түвшин
1	Шилийн богд	2004	Дурсгалт газар	17924.75294	УТХГ
2	Хөргийн хөндий	2004	Дурсгалт газар	6036.256172	УТХГ
3	Дарьганга	1993, 2004	Байгалийн цогцолборт газар	33375.34384	УТХГ
4	Тодорхойгүй	2011.03.04	Ерөнхий тусгай хэрэгцээ	348151.555	ОНТХГ
5	Шилийн богд 2	2013.02.19	Дурсгалт газар	271584.384	ОНТХГ
6	Шилийн богд 2	2011.03.04	Дурсгалт газар	12934.247	ОНТХГ
7	Шилийн богд 1	2011.03.04	Дурсгалт газар	3243.02	ОНТХГ

Зураг 35. Тусгай хамгаалалттай газрын зураг



Хуудас 86

4.3.4. Түүх соёлын дурсгалт газар

Нутгийн тал хувийг эзлэн оршдог Дарьгангын нутгийн ард түмний зан заншил, түүх соёл нь аймагтаа төдийгүй улсдаа онцгой байр эзэлдэг. Дарьгангачууд үе дамжсан сүлжих, ширэх, нэхэх, хатгах, зүү ороох зэрэг урлалыг чадмаг хийдгийн дээр дархан хүний уран ухааныг шингээн мөнгөөр сийлж, цоолж, ухаж, хөөж хийдэг дахин давтагдашгүй бүтээлээрээ алдартай. Монгол орны эртний түүхийн гайхамшигт бүтээл дурсгал болох чамин тансаг хийц бүхий 13-17-р зууны үеийн хүн чулуун хөрөг хөшөө 50 гаруй байдаг бөгөөд эдгээр нь хийц, хэлбэрийн хувьд өөр хоорондоо ялгаатай байдаг. Мөн эртний хүний оромж, дархны газар, ховор 14 хөшөө дурсгал, хадны бичээс, сүг зураг, ховор булш зэрэг огт судлагдаагүй эртний түүхийн дурсгал хаа сайгүй тарууд байрлалтай тохиолдоно.

Мөн тус сум нь улсдаа Төрийн их тахилгат Алтан овоогоороо, шилийн сайн эр хийморь сүлдээ даатгаж сэргээдэг Шилийн богд уулаараа, дуу шүлгэнд мөнхөрсөн Ганга, Дуут, Холбоо нууруудаа, 13 дугаар зууны үеийн түүхийг өгүүлэх 50 гаруй хүн чулуун хөргөөрөө, жил бүрийн намартаа чуулах мянга мянган хунгаараа, сийлж, ухаж, хөөж хийдэг дахин давтагдашгүй мөнгөн урлалын үе дамжсан Дарьганга хийцээрээ, Монголд байгаа 400 гаруй галт уулын 50 хувь нь оршдогоороо, тэгш тал дээр буй болсон Талын агуйгаараа, улс, бүс, аймгийн наадамд түрүүлдэг хурдан шандаст хүлэг морьдоороо алдартай.

Хүснэгт 44. Түүх соёлын дурсгалт газрын байршил

Д/д	Дурсгалт газрын төрөл	Хөрөг	Байгалийн цогцолборт газар	Булш	Туурь	Дурсгалт газар
1	Үүд баг	1				
2	Бадрах баг	3	5	2		
3	Аман-Ус баг	2			2	
4	Овоот баг	1	3	3	2	2
Нийт		7	8	5	4	2

Зураг 36. Байгалийн цогцолборт газар болон түүх соёлын дурсгалт газрын зураг



Дарьганга суманд аялал жуулчлалын ач холбогдол бүхий аймгийн хэмжээний гол түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд олон байдаг бөгөөд тэдгээрээс голлох үзвэрүүдийн заримаас товч тайлбарлавал.

1. **Алтан-Овоо**

Алтан овоо нь 1354 метр өндөр унтарсан галт уул бөгөөд уулын шовгор хэлбэр нь эвдрээгүй үлдсэн, хүрмэн чулуу ихтэй, амсар нь баруун хойшоо сэтэрч гарсан байдаг. Алтан-Овоог бүр 1700-аад оноос нутгийн тахилгатай, 1913 оноос төрийн их тахилгатай болгосон билээ.

Нутгийн ард түмэн олон зууны турш шүтэж, тахиж ирсэн овоо бол Дарь Овоо юм. Дарь Овоо нь далайн түвшнээс дээш 1354 м өргөгдсөн бөгөөд Молцог элсний хойт захад, Дарьганга сумын төвийн баруун хойт захад оршдог. Аймгийн төвөөс 180 км зайтай, эртний сөнөсөн галт уулсын нэг юм. Галт уулын шовгор хэлбэр нь эвдрээгүй үлдсэн, галт уулын хүрмэн чулуу их, амсар нь баруун хойшоо сэтэрч урссан. Одоогоор Монгол улсын төрийн тахилгат уулсын нэг. Алтан-Овоог бүр 1700-аад оноос нутгийн зон олон тахиж ирсэн бөгөөд, 2004 онд Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар төрийн их тахилгат уул болгосон. Дарьгангын байгалийн цогцолборт газарт багтана. Дарь Овооны зүүн урд хормойд байдаг дөрвөн чулуун хөргийг 1998 онд улсын хамгаалалтад авсан.

1911 оны Үндэсний хувьсгалаар Дарьгангачууд Монгол улсдаа нэгдэж, Богд хааны зарлиг ёсоор 1913 оны намрын дунд сарын 12-нд Алтан Дарь Овооны тахилгыг хийсэн байна. Овоог анх тахихдаа Богдын засгийн газрын Ерөнхийлөн захирах яамны төлөөлөгч дэс түшмэл, хонин сүргийн дарга Доржийн Магсаржав Богд хааны зарлигийг олон түмэнд уншиж сонсгон, овоон сүмийн Орлой мэргэн хутагт, бусад лам нарынхаа хамт ном уншиж

тахилгыг нээдэг байв. Энэ үед овоон дээр овооны сахиус болгож цагаан морь сэтэрлэж, хүж арцаар ариусган, рашаан, айраг, сүү зэргээр мялаах бусад ёслолыг гүйцэтгэдэг байна. Сүргийн гар бүр идээ, ууц, бөх, морины бай шагналын зүйлийг бэлтгэж ирдэг. Тахилгын үеэр овоог гурван удаа тойрч мөргөдөг. Дээд замаар лам, хэргэмтэн, дунд замаар эрэгтэйчүүд, доод замаар эмэгтэйчүүд тойрч явдаг ажээ.

2. Ноён, Хатан, Хүү, Бэрийн чулуу

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн тийш Ноён, хатан, хүү, бэр нэртэй дөрвөн хүн чулуун хөшөө бий. Энэхүү дөрвөн чулууг хоорондоо өөр төрлийн, өнгө зүс ялгаатай чулуугаар харилцан адилгүй ур чадвар гарган хийсэн боловч ерөнхий байдал, өмсгөн дүрсэлсэн хувцас эд хэрэглэлээр нь нэгэн цаг үед хамаарах соёлын дурсгал болохыг тогтоожээ. Ард түмний дунд Бэр хөшөө хэмээн нэрлэгдэн ирсэн хүн чулууг ШУА-ын Археологийн хүрээлэнгийн захирал Д.Цэвээндорж судлан эрэгтэй хүний баримал байна гэж тогтоожээ. Нутгийн ардууд ахуй амьдралдаа ойртуулах замаар домоглон Бэр хөшөө хэмээн нэрийддэг байсан байх хэмээн тайлбарлажээ. Түрэгийн үед хамаарах хувцас хэрэглэл бүхийгээр дүрслэгдсэн хүн чулуунууд буруу энгэртэй байдаг бол Монголын түүхэнд холбоотой хүн чулуунуудын дээл хувцасны энгэр нь зөв байдгаараа ялгарна.

3. Ганга нуур, Оргихын булаг

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс 12 километрт орших салхины нүүдлээс үүссэн хурмал элсэнд хаагдаж тогтсон нэгэн нуур байх бөгөөд түүнийг Ганга нуур гэдэг. Ганга нуур нь 4 ам километр талбайтай нуур бөгөөд Ганга гэдэг нь үүрд ширгэшгүй ундран оргилдог мөнх гэсэн утгатай үг ажээ. Ганга нууранд Монголын улаан номд ордог гангар хун, цэн тогоруу гэх мэт нэн ховор шувууд ирж зусдаг. Жил бүрийн намар хун шувууд олон зуугаараа нисэн ирж ганганан чуулдаг учраас Ганга нуурын 1000 хунгийн чуулган гэж алдаршсан юм. Ганга нуурыг усыг 21 булаг тэтгэн тэжээдэг бөгөөд тэдний гол амин судас нь Дагшин оргихын булаг билээ.

Нуурын зүүн хойно 50 метр зайд газрын гүнээс тунгалаг устай хүйтэн булаг оргилон гардгийг Оргихын булаг гэж нэрлэдэг. Нарийн ширхэгтэй элсний доороос даргилан буцалж байгаа юм шиг оргилон гарах бөгөөд чангаар дуугарах тусам улам ихээр элс бужигнан оргилдог онцлогтой билээ.

4. Торой бандийн хөшөө

Халхын шилийн сайн эрсийн нэг "Төрийн бөөс" хэмээн алдаршсан Тоорой банди буюу Нанзад 1834 оны үед Бударын чулуу гэдэг газар төржээ. Чойном гуайн уянгалсан алдарт сүмтэй Бударын чулуу.

Нанзад цахар хүн бөгөөд 1860-аад онд цахар найман хошуу төдийгүй халх даяар нэр нь түгсэн шилийн сайн эр байлаа.Тоорой бандийн тухай бичиж үлдээсэн зүйл үгүй бөгөөд олны ам дамжсан домог хууч элбэг. Багаасаа ээжтэйгээ ядуу тарчиг өссөн ба эрийн цээнд хүрээд эр чадлаараа баяд ноёд, харийн худалдаачдын эсрэг тэмцэн олсон олзоо дан ганц амин хувьдаа бус нутгийн олонтойгоо хуваадаг байсан нь олон түмний хүндлэл хайрыг хүртжээ. Мөн тэр дуулж хуурддаг авъяаслаг нэгэн байжээ. Насан өндөр болоод Нанзад гуай Бударын чулуу ,Таван толгой , Шартын хад хавиар нутаглаж байгаад 1904 онд нас баржээ.

Ганга нуураас зүүн хойшоо 6 км-т Гангын Цагаан овоо хэмээх уул бий. Түүний тогоон доторх жижигхэн довцог дээр Торой бандийн хөшөө байдаг. Гангын цагаан овоо уулыг урьд цагт тахидаг байжээ. Энэ хөшөөнд торой бандийг суугаа байдлаар нэг гараараа өвдгөө тулж, нөгөө гартаа аягатай зүйл барьж хажуудаа малгай, буу, богц зэргийг тавьснаар дүрсэлсэн аж.

Хөшөөг хүрэн будгаар будан өмнө зүгт хандуулан тавьжээ. Торой бандийн хөшөө байгаа довцгийн доор 1.2 метр орчим диаметртэй хүрэл тогоо бас байдаг. Дарьганга нутагт Орлой хөх Бух Нэйрэн зэрэг олон сайн эр байсны нэг нь халхын сайн эр гэж түмэнд нэрлэгдсэн Торой банди юм.

5. Шилийн богд

Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас зүүн урагш 60 км-т д.т.дээш 1778 метрт оршдог Дарьгангын энэ өндөрлөг тэгш газарт 200 орчим унтарсан галт уул байдгийн хамгийн өндөр нь **Шилийн богд уул** юм. Богд уул гэх нэршил нь сүүлд Буддын шашны нөлөөгөөр нэмэгдэж нэрлэгдсэн нэршил бөгөөд эрт дээр үеэс

Монголчууд **"Шивээт шил"** "Агшуун" хэмээн нэрийддэг байсан ба тал нутгийн их хайрхан хэмээн тахин шүтэж иржээ.

Мөн энэ нутагт 60 орчим хүн чулуу бий. Шилийн Богд уулын тогоо нь баруун хойшоо сэтрэн урссан бөгөөд амсар нь 2 км орчим өргөн, 300 орчим м гүнзгий ажээ. Шилийн Богд уулан дээрээс Зотол хан, Дөш зэрэг 200 орчим эртний сөнөсөн галт уулыг харж болох бөгөөд уулсын оройг зориуд засч янзлан зүсэж авсан мэт үзэсгэлэнтэй харагдана. Энэ хавийн уулс нь Авдар, Дөш, Сэнжит, Ацаа гэхчилэн галт уулын шовгор дүрс хэлбэрээрээ нэрлэгдсэн байдаг. Их талын хамгийн өндөр уул учраас тал дээр хааш хаашаа 60-аад км алсаас майхан шиг шовгор харагддаг. Шилийн богдын зүүн дор Агтны хүрээ гэж дугуй тогоотой талын намхан талт уул бий. Шилийн Богд дээрээс тод харагдана. Эртнээс нааш Монголчууд Шилийн богдыг шүтэн биширч өглөөний ургах нарнаар гарсан эр хүний хийморь сэргэж хүлгийн шандас хөвчирдөг гэлцдэг. Уулсын хоорондын хөндий талаар хүрмэн чулуун лав тогтсон тул тэдгээрийг гадарга нилээд чулуурхаг юм. Хар хүрэн, хүрэн бараан хөрс зонхилдог. 108 зүйлийн ургамал ургадаг бөгөөд ойт хээр, хээр, говийн бүсийг төлөөлөлж чадах нэн ховор ургамал 30 гаруй зүйл бий. Амьтны аймгийн хувьд туурайтан мэрэгчид голлох бөгөөд цагаан зээр, тарвага, чоно, үнэг элбэг үзэгдэнэ.

6. Талын агуй

Талын агуй нь Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт Шилийн богд уулаас хойш 15 км зайд, тэгш талд оршино. Агуйгаас зүүн урагш 2 км-д унтарсан галт уул бий. Талын агуй х.ө.45°35'25,00", з.у.114°30'02,06" газарзүйн солибцолд оршино. Агуйн ам далайн түвшнээс дээш 1250 м өндөрт, 4.5 м гүн 484м^3 ус цуглуулах талбай бүхий хонхорын зүүн талын ёроолд оршино. Энэ агуй тэгш талд байрлах тул олж очиход нилээд түвэгтэй боловч агуйн дэргэд чулуун овоо босгосон тул тал газар нилээд содон байдаг. Агуйн ам нь чанх баруун тийш харсан байх ба дөнгөж хүн багтаж орохоор нарийн амсраар шурган ордог юм. Агуйн амны хүрмэн чулуу ихээхэн элэгдэлд орж нуралт үүсэж байгаа тул агуйн аман дээр анхааруулах бичиг байрлуулсан бий. Энэ агуйн морфометрийн хэмжилт, план зүсэлтүүдийг 1998 оны 02 сарын 15-нд хийж агуйн хэсгүүдийн уртыг тодорхойлов. Агуйг үзэж сонирхож байсан хүмүүс сонин хэвлэлд /1977 он/ хэд хэдэн мэдээ бичсэн ба агуйн план, зүсэлтийг хийсэн байдаг юм. Талын агуй нь манай оронд одоогоор мэдэгдээд байгаа галт уулын гаралтай хамгийн том, урт агуй юм. Талын агуй нь зүүн тийш чиглэсэн ганцхан гол хонгилтой бөгөөд хонгилын хойд талаас 2

салаа гарах боловч нэг нь эргэж гол хонгилдоо нийлдэг, нөгөө агуйн ам нь нэг чиглэлд эргэж 11м үргэлжлээд төгсдөг. Агуй нийтдээ 245м гаруй урт юм.

Агуйд ормогц маш сэрүү татан сэнгэнэдэг. Дараагийн тасалгаа нь хүрмэн чулуун асга бүхий байдаг бол гурав дахь хонгил нь мөсөөр хучигдсан байдаг байна. Өвөлдөө 40 градус хүйтэн, мал хүртэл тогтож бэлчдэггүй энэ газарт анчин гөрөөчид их ирдэг байсан учраас Талын агуйг “Гөрөөчдийн агуй” ч гэж нэрлэдэг байж. Зун дэлгэр цагт анчид агнасан зээр, гөрөөс, тарвага, зурмаа Талын агуйд хийж орхиод хэдэн хоногоор явсан ч авласан ав нь хөлдөж найдвартай хадгалагддаг байжээ. Талын агуй газар доогуурхи жимээрээ 70 километр үргэлжилж Дарьгангын Зүүн нартын агуйтай холбогддог юм байна. Гэвч Талыг агуйн тасалгаанууд одоо газрын нуралтын улмаас шороонд дарагдсан байгаа бөгөөд агуйн дээгүүр уул уурхайн хүнд даацын машинууд явснаас шалтгаалсан хэмээн үздэг. Агуйг хамгаалах, мөн иргэдэд үйлчлэх зорилгоор хааш хааш нь 250 метр хашаа барьж машины замыг хааж жуулчны бааз барьсан байна.

7. Бичигтийн шахаа

Энэ газар нь одоогийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 40-өөд км-т байдаг. Зүүн талаасаа огт мэдэгдэхгүй цэлийсэн тал үргэлжилж байгаад гэнэт доош цөмрөх мэт эгц буусан 40-өөд м-ийн өндөртэй, 90 градиусын эгц, 1 км хэртэй урт хадан хясаа юм. Буу зэвсэг ховор байсан үед хүмүүс энэ гайхамшигт хясааг ан гөрөөний ажилд ашиглан зээр гөрөөсийг үй олноор нь сууриар нь шахаж оруулан агнадаг байжээ. Ийм учраас “Шахаа” нэрийг олсон байна гэсэн домогтой. Энэ “шахаа”-г “Бичигтийн” гэж нэрлэсэн тухайд: уул хадан хясааны эгц энгэрүүдээр их хэмжээний бичгүүд байснаас болсон гэх бөгөөд тэр бичгүүдийг “Амьтныг ингэж үүрээр нь сүйтгэж болохгүй” гэсэн харуулын бичээс байсан гэсэн домог үлджээ.

4.3.5. Ан амьтны тархалт

Дарьганга сумын хувьд усны шувууд ихээр цугладаг бөгөөд Шилийн богд, Молцог элс орчмоор нэн ховор болон ховор ан амьтан ихээхэн тарсан бөгөөд аргаль хонь, бор гөрөөс, бор туулай, дагуур зурам, мануул, монгол тарвага, саарал чоно, хярс, шар үнэг, илбэнхи тархсан байна. /Зураг 37

Хүснэгт 45. Усны амьтдын тархал

Д/д	Нуур	Усны амьтад
1	Ганга нуур	Халтар шунгуур, Отгот шунгуур, Хөх дэглий, Буухал галуу, Гангар хун, Хондон ангир, Анхидал ангир, Зэрлэг нугас, Зэрлэгшир нугас, Ногоохон нугас, Бор нугас, Зээрд нугас, Шортгор алаг нугас, Халбага нугас, Улаан хүзүү, шумбуур, Гээгт шумбуур, Алаг шунгаач, Хархираа тогоруу, Цэн тогоруу, Өвөгт тогоруу, Халзаг түнжүүр, Хонин тоодог, Хондлой цагаан
2	Эрдэнэ нуур	Халтар шунгуур, Отгот шунгуур, Хөх дэглий, Гангар хун, Хондон ангир, Анхидал ангир, Зэрлэг нугас, Ногоохон нугас, Бор нугас, Зээрд нугас, Хархираа тогоруу, Цэн тогоруу, Өвөгт тогоруу
3	Холбоо нуур	Халтар шунгуур, Ухаа шунгуур, Отгот шунгуур, Хөх дэглий, Гангар хун, Хондон ангир, Анхидал ангир, Зэрлэг нугас, Бор нугас, Зээрд нугас, Хархираа тогоруу, Цэн тогоруу, Өвөгт тогоруу
4	Дуут нуур	Монгол бах, Халтар шунгуур, Ухаа шунгуур, Отгот шунгуур, Хөх дэглий, Гангар хун, Хондон ангир, Анхидал ангир, Зэрлэг нугас, Бор нугас, Зээрд нугас, Хархираа тогоруу, Цэн тогоруу, Өвөгт тогоруу

Зураг 37. Амьтны тархалтын нөөцийн зураг



4.3.6. Ховор ургамлын тархалт

Дарьганга сумын хувьд Молцог элс, Шилийн богд орчмоор гишүүнэ, дэрвэгэр жиргэрүү, нангиад зээргэнэ, өргөст цэцэг, сөд өвс, тайжийн жинс, тарваган шийр, тэхийн шээг, цагаан төмс, цагаан цахилдаг, эмийн багваахай, алтан гагнуур, цагаан уул, булцуут туйплан, нохойн хошуу, хунчир, таван салаа тархсан байна. /Зураг 38

Зураг 38. Ховор эмийн ургамлын тархалтын зураг



4.4.АЖ АХУЙН ТӨРӨЛЖИЛТИЙН СУДАЛГАА

Сумын хэмжээнд нийт 25 аж ахуйн нэгж, иргэн аж ахуйн зориулалтаар газар ашиглаж байгаа бөгөөд дийлэнх хувь нь ноос, ноолуур, эсгий, арьс шир, гутал, оёмол сүлжмэл, хэвлэл модон эдлэл зэрэг хөнгөн үйлдвэрлэл эрхэлж байна. Орон нутагт цаашид байгалийн тодорхой нөөцийг ашиглан үйлдвэрлэл эрхлэх зах зээл байгааг харуулж байна.

Хүснэгт 46. Орон нутагт амжилттай үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж

№	Үйлдвэрийн нэр	Аж ахуй нэгжийн хэлбэр /ХХК, хоршоо, бүлэг, нөхөрлөл/	Эзний нэр, утасны дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байгуулагдсан он	Одоо ашиглаж байгаа эсэх,/ хэдэн хувийг ашиглаж байгаа эсвэл зогссон/	Ажилчдын тоо

№	Үйлдвэрийн нэр	Аж ахуй нэгжийн хэлбэр /ХХК, хоршоо, бүлэг, нөхөрлөл/	Эзний нэр, утасны дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байгуулагдсан он	Одоо ашиглаж байгаа эсэх,/ хэдэн хувийг ашиглаж байгаа эсвэл зогссон/	Ажилчдын тоо
1.Хүнсний үйлдвэрийн чиглэлээр /сүү, сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн/							
1	талх , нарийн боов	Жаргалант өсөх аривжих хоршоо	Ж.Оюунтуяа	Хүнсний үйлдвэр	2015	40%	2
2	талх	Баян шарга ХХК	Д.Эрдэнэтулга	Хүнсний үйлдвэр	2012	100%	6
2.Хөдөө аж ахуйн чиглэлээр /мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа							
3	Газар тариалан,	Ургах наран бүлэг	Н.Урьдыбиш	Хөдөө аж ахуй	2015	50%	10
4	Газар тариалан,	Шинэ оргил бүлэг	Э.Сумъяа	Хөдөө аж ахуй	2015	50%	10
5	Газар тариалан,	Иргэн	М.Билэгмаа	Хөдөө аж ахуй	2015	40%	2
6	Тахианы аж ахуй	Иргэн	Ж.Очгэрэл	Хөдөө аж ахуй	2014	50%	2
7	Сүүний чиглэлийн	Иргэн	Б.Одбаяр	Хөдөө аж ахуй	2014	50%	2
3.Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр /ноос, ноолуур, эсгий, арьс шир, гутал, оёмол сүлжмэл, хэвлэл модон эдлэл							
8	Гар урлал	иргэн	Б.Баярхүү	Хөнгөн үйлдвэр	2014		1
9	Гар урлал	Иргэн	М.Сарантуяа	Хөнгөн үйлдвэр	2014		1
10	Түүхий эд,	иргэн	Д.Мөнхбаяр	Хөнгөн үйлдвэр	2014		1
11	Өрнөн Бадрах Оёдол	иргэн	Л.Борхүүхэн	Хөнгөн үйлдвэр	2013		2
12	Модон эдлэл	иргэн	Р.Батнаран	Хөнгөн үйлдвэр	2013		1
13	Гэр ахуйн модон эдлэл	иргэн	Б.Болдбаяр	Хөнгөн үйлдвэр	2013		1
14	Оёдол	иргэн	Д.Наранцэцэг	Хөнгөн үйлдвэр	2015		1
